

ТАХЬКО (ХК) КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД**ХҮРГЭХ ТАНИЛЦУУЛГА**

Тахько (ХК) компани Монгол улсын Засгийн газрын Өмч хувьчлалын комиссын 1992 оны 3 дугаар сарын 5-ны өдрийн 32 дугаар тогтоолоор хувьчлагдах шийдвэр гарч, Тахько хувьцаат компани (100 хувь хувийн өмчид шилжсэн) байгуулагдсан үеэс өнөөдрийг хүртэл тасралтгүй үйл ажиллагаа явуулж байна.

Тус компани 1992 онд буюу хувьчлагдах үеийн эхлэлтийн балансаар 345,567.5 мянган төгрөгийн өөрийн хөрөнгөтэй, нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 592,830 ширхэг энгийн хувьцаатай байсан бол 2025 оны жилийн эцсийн байдлаар 10,726,593.8 мянган төгрөгийн хөрөнгөтэй, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй нэг бүр нь 168 төгрөгийн нэрлэсэн үнэтэй нийтэд зарласан чөлөөтэй арилжаалагдах 1,189,983 ширхэг энгийн хувьцаатай нээлттэй хувьцаат компанийн хэлбэрээр ажиллаж байна.

УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**Компанийн засаглал**

Тахько (ХК) компанийн захиргаа (гүйцэтгэх удирдлага, зохион байгуулалтын нэгж) 2025 онд Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал, Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан шийдвэрийг хэрэгжүүлж, Компанийн тухай хууль, Компанийн дүрэм, Монголын компанийн засаглалын кодекс, стандартын шаардлагыг мөрдөж, засаглалын үйл ажиллагааг ил тод явуулж ажилласан.

Компани 2024 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, 2024 оны санхүүгийн тайланд аудит хийлгэсэн Солид юнити аудит компанийн дүгнэлт, Хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зарлан хуралдуулах, аудитын компани сонгох зэрэг асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, гарсан шийдвэрийг хэрэгжүүлж ажилласан.

Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуульд заасан хугацаа, төрийн эрх бүхий байгууллагаас баталсан журамд заасан шаардлагад нийцүүлэн хийж, хүчин төгөлдөр саналын эрхийн 89.6 хувийн ирцтэйгээр хуралдуулж, хурлаар хэлэлцсэн Компанийн 2025 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох, дотоод ажлын зардлын төсвийг батлах асуудлуудыг хуралд оролцогчдын 95.4-100 хувийн саналын эрхээр тус тус батлуулж шийдвэрлүүлсэн.

2025 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн 6, хараат бус 3 гишүүн сонгогдсон. Сонгогдсон гишүүд өмнө нь компанийн засаглалын сургалтад хамрагдсан, үүнээс хараат бус гишүүд нь Компанийн хуульд заасан шаардлага, шалгуурыг бүрэн хангаж байгаа бөгөөд сонгогдсон гишүүдийн тухай мэдээллийг Хөрөнгийн биржийн болон компанийн цахим хуудсаар олон нийтэд мэдээлсэн болно.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарсан шийдвэр, холбогдох бусад баримт бичгийг Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж ТӨХК (Арилжаа эрхлэх байгууллага)-д хуульд заасан хугацаанд хүргүүлж, хууль тогтоомж, төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан журам, хугацааны заалтыг биелүүлэн ажилласан.

Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр (ТУЗ-ийн 2025.02.19-ний № 01 тоот тогтоол)-ийн дагуу компанийн 2024 оны цэвэр ашгаас 1,187,883 ширхэг энгийн хувьцаанд хуваарилсан 122,934.9 мянган төгрөгийн ногдол ашгаас хувь хүн ба аж ахуйн нэгжийн орлогын албан татварт 6,414.7 мянган төгрөг суутган харьяалах татварын байгууллагад шилжүүлэн тайлагнаж, 121,876.7 мянган төгрөг (Үүнээс 116,788.2 мянган төгрөгийн ногдол ашгийг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв компаниар зуучлуулан, 5,088.5 мянган төгрөгийн ногдол ашгийг компани дээр тус тус олгож)-ийн ногдол ашгийг бүртгэлийн өдрөөр ногдол ашиг хүртэх эрхтэй 629 хувьцаа эзэмшигчдийн төвлөрсөн хадгаламж дахь дансанд 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдөр байршуулж, хувьцаа эзэмшигчид болон олон нийтэд мэдээлж, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид тогтоосон хугацаанд тайлагнасан.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1-20.1.10, Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 225 дугаар тогтоол, Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны 9/132, Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн 2025 оны 01/39, 01/234 тоот бичгээр ирүүлсэн зөвлөмж, шаардлага, мэдэгдэл үүргийг тус тус хэрэгжүүлж санхүүгийн ба санхүүгийн бус тайлан, хугацаат ба тухай бүр мэдээлэх мэдээллийг хувьцаа эзэмшигч, олон нийт, холбогдох байгууллагуудад тогтоосон хугацаанд мэдээлэх үүргийг биелүүлж ажилласан.

Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны бүртгэлийн журмын 10.7-д заасан үүргийн дагуу Тахько (ХК) компанийн улирлын болон эхний хагас жилийн засаглалын үйл ажиллагааны тайлангуудыг гаргаж Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж ТӨХК-д хүргүүлж тайлагнасан.

Компанийн веб хуудасны мэдээ мэдээллийг шинэчилж, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан журмын дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлын зар, хэлэлцэх асуудал, хурлаас гарах шийдвэрийн төсөл, Хувьцаа эзэмшигчдийн болон Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэр, компанийн бусад мэдээллийг мэдээлж, хувьцаа эзэмшигч болон олон нийтийг мэдээллээр хангах үүргийг биелүүлэн ажиллаж байна.

2025 онд их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй гэрээ хэлцэл хийгдээгүй, үнэт цаасны ханш, арилжааны хэмжээнд мэдэгдэхүйц нөлөөлөх нөхцөл байдал үүсэж бий болоогүй болно.

Компани 2025 онд Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж ТӨХК (Арилжаа эрхлэх байгууллага)-ийн тогтоол, шийдвэр, журмаар тогтоосон нээлттэй хувьцаат компанид холбогдох заалтууд болон үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг биелүүлэн ажилласан.

Тахько (ХК) компани 2025 онд компанийн засаглалын зарчим, үйл ажиллагааг хэрэгжүүлж Монголын хөрөнгийн биржийн Үнэт цаасны бүртгэлийн журмын 12 дугаар зүйлийн 12.1-ийн 12.1.1-12.1.4, 12.2-ын 12.2.1-12.2.4 дэх хэсэгт заасан үнэт



цаас гаргагч болон үнэт цаасны шалгуур (тогтвортой үйл ажиллагаа явуулж байгаа, санхүүгийн тайланг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (IFRS)-ын дагуу гаргах, Санхүүгийн зохицуулах хорооны зөвшөөрөлтэй аудитын байгууллагаар баталгаажуулах, үйл ажиллагаагаа явуулахад шаардагдах хангалттай хэмжээний ажлын капиталтай байх эсхүл 100 сая төгрөгөөс доошгүй хэмжээний ашигтай ажилласан, компанийн засаглалын зарчмыг дагаж мөрддөг, компанийн зах зээлийн үнэлгээ, гаргасан үнэт цаасны нийтэд санал болгосон хувь, компани нь засаглалын болон мэдээллийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх зэрэг)-ын дагуу хоёрдугаар ангиллын нээлттэй компанийн шаардлагыг хангаж ажилласан.

Компанийн бүтэц, зохион байгуулалт

Компани нь 2025 онд захиргаа, хүний нөөцийн хэсэг, техник үйлчилгээний хэсэг, санхүүгийн хэсэг, Анкор төв гэсэн бүтэцтэй, 19 орон тоотой ажиллахаар төлөвлөж, 17 ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулж ирсэн.

Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу ээлжээр ажилласан ажилтнуудад шөнийн цагаар ажилласны нэмэгдэл хөлс олгож, ажилтнуудыг шөнийн ба илүү цагаар ажилласан тохиолдолд биеэр нөхөж амраадаг болсон.

Компанийн 2025 оны санхүүгийн тайланг “А” форматаар болон санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (IFRS)-ын дагуу гаргаж, Солид Юнити аудит ХХК-аар олон улсын түвшний аудитын баталгаажуулалт хийлгэж, Төлөөлөн удирдах зөвлөл болон 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлэн батлуулж, дүгнэлт тайланг Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлсэн.

Компанийн дүрмээр олгосон эрх хэмжээний хүрээнд өмч хөрөнгө, бараа, ажил, үйлчилгээ, компанийн хэвийн үйл ажиллагааг хангахтай холбоотой хангамжийн материал, сэлбэг хэрэгсэл, түлш шатахуун худалдан авах, хөрөнгийн засвар хийх, үйлчилгээ үзүүлэх зэрэг компанийн өдөр тутмын үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр 113 гэрээ байгуулж, тэдгээр гэрээгээр гүйцэтгэсэн ажил, үйлчилгээ, ажлын үр дүнг хүлээн авч, төлбөр тооцоог хийж дуусгасан.

Компанийн өмч хөрөнгийг эрсдэлээс хамгаалах зорилгоор Практикал даатгал, Миг даатгалын компаниудтай үл хөдлөх хөрөнгө болон тээврийн хэрэгслийн даатгалын гэрээ шинээр байгуулж даатгалын хураамжинд 9,616.7 мянган төгрөг төлсөн.

Оёдлын үйлдвэрийн нэгдэл болон Тахько ХК-иас өндөр насны тэтгэвэрт гарсан ахмадуудад Монголын уламжлалт Сар шинийн баяраар 33, Ахмадын баяраар 22 ахмадуудад хүндэтгэл үзүүлж, мөнгөн урамшуулал олгосон.

Компанийн үр ашгийг дээшлүүлэхэд ажил үйлсээрээ манлайлан, үүрэгт ажилдаа амжилт гарган ажиллаж Монгол Улсын Ерөнхийлөгчийн шагналаар шагнагдсан “Алтан гадас одон”-1, “Хөдөлмөрийн хүндэт медаль”-1, нийт 2 ажилтанд шагналын дагалдах 462.0 мянган төгрөгийн мөнгөн урамшууллыг олгов.

Анкор төвд тайлант хугацаанд нийт 36 удаагийн, 108 цагийн арга хэмжээ, үйлчилгээ зохион байгуулж, 71,659.09 мянган төгрөгийн орлого олсон байна. Компани нийгмийн хариуцлагын хүрээнд Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газар, Чингэлтэй дүүргийн Татварын хэлтэс, Ерөнхий боловсролын “Олонлог”

сургууль-ийн зохион байгуулсан арга хэмжээнүүдийг хөнгөлөлттэй нөхцөлөөр зохион байгуулж дэмжлэг үзүүлсэн. Жилийн эцсийн байдлаар Анкор төвийн түрээсийн үйл ажиллагаанаас 71,659.09 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, төлөвлөгөөний гүйцэтгэл 89.57 хувь-тай биелсэн байна.

ОРЛОГО НЭМЭГДҮҮЛЭХ, ХЭВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХАНГАХ

Компанийн орлого нэмэгдүүлэх, бизнесийн үйл ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр

Компанийн орлогын тогтвортой өсөлтийг хангах, үндсэн үйл ажиллагааны хэвийн тасралтгүй байдлыг баталгаажуулах, бизнесийн цар хүрээг нэмэгдүүлэх стратегийн зорилтын хүрээнд түрээсийн менежментийг сайжруулах, ашигт ажиллагааг нэмэгдүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээнүүдийг үе шаттай авч хэрэгжүүлэв.

Энэ хүрээнд компанийн эзэмшлийн МА-2 барилга буюу Теди төвийн 2, 3, 4 дүгээр давхрын талбайн түрээсийн гэрээний хугацаа дуусахтай холбогдуулан зах зээлийн нөхцөл байдал, байршлын давуу тал, талбайн ашиглалтын үр өгөөжид тулгуурлан түрээсийн үнийг 16 хувиар нэмэгдүүлэхээр тохиролцож, гэрээний хугацааг сунгасан.

Ньюком Проперти ХХК-тай байгуулсан түрээсийн гэрээний нөхцөлийг шинэчлэн, дараах үр дүнд хүрсэн болно. Үүнд:

- Түрээсийн орлогыг 16 хувиар нэмэгдүүлж, компанийн мөнгөн урсгалын тогтвортой байдлыг сайжруулав.
- Түрээсийн гэрээний хугацааг урт хугацаагаар сунгаснаар сул зогсолтын эрсдэлийг бууруулж, орлогын тасралтгүй байдлыг хангаж ажиллав.
- Барилгын ашиглалтын түвшинг хадгалж, эзэмшлийн үл хөдлөх хөрөнгийн өгөөжийг нэмэгдүүлэв.
- Хамтын ажиллагааг бэхжүүлж, цаашдын өргөтгөл, хамтарсан төслүүд хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэв.

Дээрх арга хэмжээ нь компанийн орлого нэмэгдүүлэх бодлоготой уялдуулан үндсэн үйл ажиллагааг санхүүгийн хувьд тогтвортой, үр ашигтай явуулахад бодит дэмжлэг үзүүлсэн.

Компанийн өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангах чиглэлээр

2025 онд хийгдсэн их засварын ажил

МА-1 барилга

МА-1 барилгын залгаа гараашийн дээврийн бетон цутгалт, хар цаас наах ажлыг “Алт Мөнгөн Багана” ХХК-тай 2025 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн АГ/2025-55 дугаартай ажил гүйцэтгэх гэрээ байгуулан 37,107.0 мянган төгрөгийн зардлаар гүйцэтгүүлсэн. Ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан бөгөөд гүйцэтгэл 100 хувьтай хэрэгжсэн.

МА-2 барилга

Тэди төвийн автомашины зогсоолын 2,010 м² талбайд 5–10 мм зузаантай асфальт бетон хучилтын ажлыг “Таван Огторгуй” ХХК-тай 2025 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн АГ/2025-13 дугаартай ажил гүйцэтгэх гэрээ байгуулан 198,141.4 мянган төгрөгийн зардлаар гүйцэтгүүлсэн. Ажлын гүйцэтгэлийн явц, чанарт тогтмол хяналт тавьж ажилласан бөгөөд илэрсэн зөрчил, доголдлын талаар гологдлын акт үйлдэн удирдлагад танилцуулж, холбогдох засвар, сайжруулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Тэди төвийн автомашины зогсоолын 2,010 м² талбайд 5 мм асфальт хучилт хийх, замын тэмдэг, тэмдэглэгээ хийх болон дугуйны хязгаарлагч суурилуулах ажлыг “Сарт Уудам Рөүд” ХХК-тай 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн АГ/2025-54 дугаартай ажил гүйцэтгэх гэрээ байгуулан 90,000.0 мянган төгрөгийн зардлаар гүйцэтгүүлсэн. Гэрээний дагуу ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан бөгөөд ажлын гүйцэтгэл 100 хувьтай хэрэгжсэн.

МА-3 барилга

Мобикомын архив байрлаж байсан хүзүүвчний хэсгийн 96 м² талбайд иж бүрэн засвар хийж, 41 м² талбайн өргөтгөл гүйцэтгэн, нийт 107 м² барилгын засвар, шинэчлэлийн ажлыг “Алт Мөнгөн Багана” ХХК-тай 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн АГ/2025-27 дугаартай ажил гүйцэтгэх гэрээ байгуулан 226,678.0 мянган төгрөгийн зардлаар гүйцэтгүүлсэн. Ажлын гүйцэтгэлд тогтмол хяналт тавьж, 100 хувийн гүйцэтгэлтэйгээр хүлээн авч, холбогдох баримт бичгийн бүрдлийг ханган ажилласан. МА-3 барилгын 435 м² талбай бүхий дээврийн засварын ажлыг 2025 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн АГ/2025-81 дугаартай ажил гүйцэтгэх гэрээ байгуулан 78,752.0 мянган төгрөгийн зардлаар гүйцэтгүүлсэн. Ажлын явц, чанарт хяналт тавьж, 100 хувийн гүйцэтгэлтэйгээр ажлыг хүлээн авч, баримт бичгийн бүрдлийг ханган ажилласан. Мөн Тахько ХК-ийн эзэмшлийн 170 м² талбай бүхий автомашины гараашийн иж бүрэн засварын ажлыг “Алт Мөнгөн Багана” ХХК-тай 2025 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн АГ/2025-64 дугаартай ажил гүйцэтгэх гэрээ байгуулан 114,000.0 мянган төгрөгийн зардлаар гүйцэтгүүлсэн. Чанарын баталгааны хугацаанд гологдол илэрсэн тул гологдлын акт үйлдэн баталгаажуулж, засварын ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан.

Урсгал засварын ажил

МА-1 барилга

Скайтел төвийн 2 дугаар давхрын нийтийн ариун цэврийн өрөөний бүрэн засварын ажлыг “Алт Мөнгөн Багана” ХХК-тай 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн АГ/2025-20 дугаартай ажил гүйцэтгэх гэрээ байгуулан 10,000.0 мянган төгрөгийн зардлаар гүйцэтгүүлсэн. Ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, гэрээний хэрэгжилтийг ханган ажилласан.

МА-2 барилга

Барилгын зүүн талын ногоон байгууламжийн хашаа, хайсыг шинэчлэх ажлыг “Батжина Трейд” ХХК-тай 2025 оны 04 дугаар сарын 22-ны өдрийн АГ/2025-38 дугаартай ажил гүйцэтгэх гэрээ байгуулан 5,850.0 мянган төгрөгийн зардлаар гүйцэтгүүлсэн. Ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан.

Чингэлтэй дүүргийн Газар зохион байгуулалтын албанаас ирүүлсэн шаардлагын дагуу “Тахько” ХК-ийн эзэмшлийн гараашийн залгаа байрлаж байсан контейнерийг нүүлгэн шилжүүлж, явган зорчигч саадгүй зорчих боломжтой зай талбайг чөлөөлөн тохижуулсан. Мөн чөлөөлсөн хэсгийн зохион байгуулалтыг оновчтой төлөвлөж, компанийн үйл ажиллагаанд шаардлагатай жижиг агуулахын барилгыг шинээр бариулсан. Дээрх ажлыг “Мегахас” ХХК-тай 2025 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн АГ/2025-84 дугаартай ажил гүйцэтгэх гэрээ байгуулан хэрэгжүүлсэн. Ажлын нийт төсөвт өртөг 23,500.0 мянган төгрөгийн зардлаар гүйцэтгүүлсэн. Гэрээний дагуу ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан бөгөөд ажлын гүйцэтгэл 100 хувьтай хэрэгжсэн. Ажил гүйцэтгэлийн явцад техникийн болон захиалагчийн хяналтыг тогтмол тавьж, чанар, аюулгүй ажиллагаа, стандартын шаардлагыг хангуулан ажилласан. Ажлын гүйцэтгэл 100 хувьтай хийгдэж, холбогдох акт, санхүүгийн болон гүйцэтгэлийн баримт бичгийн бүрдлийг бүрэн хангуулж архивласан болно. МА-2 барилгын урд болон хойд хэсгийн лифтний засвар, үйлчилгээний найдвартай ажиллагааг хангах зорилгоор барилгын үндсэн хийцэд суурилсан дамнуурын хүчитгэх төхөөрөмжийг батлагдсан зургийн дагуу мэргэжлийн байгууллага болох “Зэндмэнэгүүр” ХХК-тай 2025 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн АГ/2025-28 дугаартай ажил гүйцэтгэх гэрээ байгуулан 7,500.0 мянган төгрөгийн зардлаар гүйцэтгүүлсэн. Ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан. Тахько оффис, ажилчдын өрөө, дулааны узель, авто гарааш, мобил гарааш болон Анкор төвийн объектуудын камерын хяналтын системийг иж бүрэн шинэчлэн солих ажлыг “Би Си Ти” ХХК-тай 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн АГ/2025-19 дугаартай ажил гүйцэтгэх гэрээ байгуулан 17,139.7 мянган төгрөгийн зардлаар гүйцэтгүүлсэн. Ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, гэрээний дагуу хэрэгжилтийг ханган ажилласан.

МА-3 барилга

Анкор төвийн гадна фасадны өнгө сэргээх урсгал засварын ажил 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн АГ/2025-51 дугаартай ажил гүйцэтгэх гэрээгээр зохион байгуулагдсан. Ажлыг нийт 27,500.0 мянган төгрөгийн зардлаар гүйцэтгүүлсэн бөгөөд гүйцэтгэлд хяналт тавьж, гэрээний дагуу хэрэгжилтийг бүрэн ханган ажилласан байна. Анкор төвд явган хана угсрах, хана, тааз будах, гоёлын багана угсрах, мөн хурлын зааланд явган хана угсрах зэрэг засварын ажлыг “Шүлэг” ХХК-тай байгуулсан батлагдсан гэрээний дагуу гүйцэтгүүлж, ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан. Ажлын гүйцэтгэл 100 хувьтай хэрэгжсэн.

ХТП-477 дэд өртөө

ХТП-477 дэд өртөөний хэвийн, найдвартай ажиллагааг хангах зорилгоор хоёр трансформаторт тосны туршилтыг хийж гүйцэтгэсэн. Мөн тосны банкны жийргэвч резинүүдийг сольж, зориулалтын шингэнээр бүрэн угааж цэвэрлэн, 0.4 кВ, 6 кВ-ийн өндөр болон нам талын вакуум таслуур, ачаалал таслагч, рычакуудын чангалгааг хийж, иж бүрэн цетам тосолгоог гүйцэтгэсэн. Тус ажлыг “Синусойд Тех” ХХК-тай 2025 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн АГ/2025-89 дугаартай ажил гүйцэтгэх гэрээ байгуулан 5,500.0 мянган төгрөгийн зардлаар гүйцэтгүүлсэн. Ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, фото тайлан, гэрээ дүгнэсэн акт болон гүйцэтгэлийн баримт бичгийн

бүрдлийг хангуулан хүлээн авч ажилласан. Компанийн үндсэн хөрөнгө, барилга байгууламж болон ХТП-477 дэд станцын хэвийн, найдвартай ажиллагааг хангах зорилгоор ашиглалтын явцад тогтмол хяналт тавьж, арчлан хамгаалах, урсгал засвар, үйлчилгээний ажлыг төлөвлөн, батлагдсан төлөвлөгөөний дагуу үе шаттай хэрэгжүүлэн ажилласан.

Хан-Уул дүүргийн 14 дүгээр хороонд байрлах Кувэйтын аман дахь орон сууцны дотор заслын сэргээн засварлах ажлыг “Мост Сейф Транс” ХХК-тай байгуулсан ажил гүйцэтгэх гэрээний дагуу гүйцэтгүүлж, ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан. Ажлын гүйцэтгэл 100 хувьтай хэрэгжсэн. Тус орон сууцны цонхны силикон чигжээс татах ажлыг “Модун Конгру” ХХК-тай 2025 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн АГ/2025-82 дугаартай ажил гүйцэтгэх гэрээ байгуулан 4,600.0 мянган төгрөгийн зардлаар гүйцэтгүүлсэн. Мөн аянгын хамгаалалтын газардуулга суурилуулах ажлыг “Цахилгаан Цэнэг” ХХК-тай 2025 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн АГ/2025-93 дугаартай ажил гүйцэтгэх гэрээ байгуулан 11,392.0 мянган төгрөгийн зардлаар гүйцэтгүүлсэн.

Ажлын байр, ажиллах нөхцөл, аюулгүй байдал, санхүүгийн үйл ажиллагаа

Тайлант онд ажилтнуудын аюулгүй, эрүүл орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, санхүүгийн сахилга бат, хяналтыг сайжруулах чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэв.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн бодлого, жилийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажилласан. Төлөвлөгөөний биелэлтэд улирал тутам хяналт-шинжилгээ хийж, илэрсэн зөрчил, дутагдлыг тухай бүр арилгуулсан.

Ажлын байрны эрсдэлийн үнэлгээг хийж, аюул эрсдэлийн түвшинг тодорхойлон, өндөр болон дунд эрсдэлтэй ажлын байранд нэмэлт хяналт, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч хэрэгжүүлсэн. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны сайдын 2019 оны А/370 дугаар тушаалын дагуу ээлжийн болон эрсдэлтэй нөхцөлд ажилладаг ажилтнуудыг мэргэжлийн сургалтад хамруулж, нэгдсэн эрүүл мэндийн багц үзлэг, шинжилгээнд бүрэн хамруулсан. Оффис, гарааш, ээлжийн ажилтны өрөө, дулааны узель, дэд өртөө, анкор зэрэг объектуудын хяналтын камерын системийг иж бүрэн шинэчилж, дүрс бичлэгийн чанар, хадгалалтын хугацааг сайжруулсан.

Галын аюулгүй байдал

Гал түймрээс урьдчилан сэргийлэх болон хамгаалах тоног төхөөрөмж, анхан шатны багаж хэрэгслийг шинэчлэн худалдан авч, галын иж бүрэн сараа байгуулсан. Гал унтраах бодис, материал, олон төрөлт галын хоруудад техникийн үйлчилгээ хийж, ашиглалтын хугацаа, бэлэн байдлыг бүрэн хангуулсан. Галын аюулгүй ажиллагааны зааварчилгаа, дадлага сургуулилтыг зохион байгуулж, ажилтнуудын бэлэн байдлыг нэмэгдүүлсэн. Нийт ажилтнуудыг Чингэлтэй дүүргийн Онцгой

байдлын газрын мэргэжилтнээр галын анхан шатны аюулгүй ажиллагааны сургалтад хамруулж, мэдлэг, ур чадварыг дээшлүүлсэн байна.

Ажлын байрны эрүүл, аюулгүй, таатай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор 17,995.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө (компьютер, дагалдах хэрэгсэл) болон 2,420.6 мянган төгрөгийн хангамжийн материал худалдан авсан. Мөн мэдээллийн болон сүлжээний аюулгүй байдлыг хангах, хяналт тавих үүргийг гүйцэтгүүлэхээр мэргэжлийн компанитай гэрээ байгуулан хамтран ажилласан.

Цахилгааны аюулгүй ажиллагааны эрх олгох 1 жилийн сургалт, Эрчим хүчний сургалтын төвд хамрагдсан. Дулааны узелийн машинист анхан шатны сургалтыг Дулаан дамжуулах үндэсний төвийн багш нарыг урьж авчиран ээлжийн ажилтнуудад бүтэн өдрийн сургалт, мөн захиргаа болон удирдах ажилтнуудад бизнесийн үндсэн сургалт, санхүүгийн программ, программ хангамж, хүний нөөцийн сургалт зөвлөгөөнүүдэд давхардсан тоогоор 21 ажилтан хамрагдаж 11,020.0 мянган төгрөг зарцуулсан.

Компанийн санхүү болон үйл ажиллагаатай холбогдсон санхүүгийн тайлан, татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан болон бусад төрийн байгууллагад тайлагнадаг статистик мэдээ, тайлангуудыг хуульд заасан хугацаанд гаргаж, илгээсэн (тушаасан) болно.

Компани 2025 онд улсын төсөвт 956,713.1 мянган төгрөг төлөхөөс 97.0 хувийг тайлангийн хугацаанд төлж барагдуулсан. Үүнд:

- ✓ Нэмэгдсэн өртгийн албан татвар 365,546.4 мянган төгрөг
 - ✓ Хүүний орлогын албан татвар 20,320.8 мянган төгрөг
 - ✓ Хувь хүний орлогын албан татвар 143,246.0 мянган төгрөг
 - ✓ Нийгмийн даатгалын шимтгэл 254,845.4 мянган төгрөг үүнд:
 - Даатгуулагч 97,685.9 мянган төгрөг
 - Ажил олгогч 157,159.4 мянган төгрөг
 - ✓ Үл хөдлөх хөрөнгийн татвар 16,689.0 мянган төгрөг
 - ✓ Газрын төлбөрт 117,310.3 мянган төгрөг
 - ✓ Авто тээврийн өөрөө явах хэрэгслийн албан тавар, агаарын бохирдол болон зам ашигласны төлбөр 2,577.9 мянган төгрөг
 - ✓ Бусад татварт 6,990.3 мянган төгрөг
- Нийт татвар хураамж 927,713.1 мянган төгрөг төлсөн.

Компани 2025 онд 4,793,274.7 мянган төгрөгийн орлоготой, 3,864,980.5 мянган төгрөгийн зардалтай, 928,294.2 мянган төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажиллаж, 2024 оны мөн үеийн гүйцэтгэлтэй харьцуулахад компанийн орлого 414,949.0 мянган төгрөг буюу 9.0 хувиар өсч, зардал 253,227.5 мянган төгрөг буюу 06,0 хувиар буурч, хуримтлагдсан ашиг 10,633,395.8 мянган төгрөг буюу 68,0 хувиар өссөн байна.

ТАХЬКО (ХК) КОМПАНИ
2026.03.24





**ТАХЬКО (ХК) КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
2026 ОНЫ ЭЭЛЖИТ ХУРЛЫН САНАЛ АВАХ ХУУДАС**

Хурал хуралдах хугацаа: 2026.04.30 Хурал эхлэх цаг: 10.00 Дансны дугаар: БААТАР ХОТ. 2061007

Хурал хуралдах газар: Тахько (ХК) компанийн байранд
(МА-III барилга буюу Анкор төвийн хурлын зааланд)

Хувьцаа эзэмшигчийн (эцэг, эхийн) (нэр)

Регистрийн дугаар Хувьцааны төрөл (энгийн, давуу)

Хувьцааны тоо

А. Ердийн аргаар санал авах асуудал

№	Хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн товч утга	Зөвшөөрсөн (+)	Татгалзсан (+)	Түдгэлзсэн (+)
1	Компанийн 2025 оны жилийн үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах.			
2	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоож, дотоод ажлын жилийн зардлыг батлах. Үүнд:	-----	-----	-----
а)	ТУЗ-ийн даргын сарын цалинг 8,000,000 төгрөгөөр тогтоох			
б)	ТУЗ-ийн ердийн гишүүний сарын цалинг 1,000,000 төгрөгөөр тогтоох			
в)	ТУЗ-ийн хараат бус гишүүний сарын цалинг 1,200,000 төгрөгөөр тогтоох			
г)	ТУЗ-ийн нарийн бичгийн даргын сарын цалинг 2,000,000 төгрөгөөр тогтоох			
д)	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд олгох жилийн урамшууллын хэмжээг компанийн 2026 оны жилийн орлогын 2.0 хүртэл хувиар тогтоох			
е)	ТУЗ-ийн дотоод ажлын жилийн зардлыг (цалин, урамшууллыг оролцуулахгүйгээр) 9,400,000 төгрөгөөр тогтоох			

Б. Кумулятив аргаар санал авах асуудал

№	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох	Нэр дэвшигчид өгөх саналын тоо
Ердийн гишүүн		
1	Лутаагийн Буянбат	
2	Лодойдамбын Галбадрах	
3	Даваадашийн Минжмаа	
4	Гантулгын Төгөлдөр	
5	Жамбаагийн Чимэдцэрэн	
6	Ганхуягийн Оюунгэрэл	
Хараат бус гишүүн		
1	Сахъяагийн Итгэл	
2	Лувсансамбуугийн Дашмягмаржав	
3	Базаррагчаагийн Сийлэгмаа	

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг, нэр ()

Санал авах хуудсыг үйлдсэн оны ... дугаар сарын -ны өдөр

Саналын хуудсыг хүчинтэйд тооцож тоолсон
Тооллогын комиссын дарга ()

Хүчингүйд тооцсон бол түүний шалтгаан.....
.....
.....
.....